



# МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ 2010/07

## БР №06(46) Бизнес регистр.

Аж ахуйн нэгж, байгууллагын регистрийн санд 2010 оны эхний хагас жилийн байдлаар 71.6 мянган аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагийн 39.8 мянга буюу 55.6 хувь нь үйл ажиллагаа явуулж байна. Регистрийн санд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын 26.5 мянга буюу 66.6 хувь нь Улаанбаатар хотод байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа эдгээр аж ахуйн нэгж, байгууллагын 84.8 хувийг 1-9 ажиллагчидтай, 6.8 хувийг 10-19 ажиллагчидтай, 5.5 хувийг 20-49 ажиллагчидтай, 2.9 хувийг 50-иас дээш ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага эзэлж байна.

Бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоо өмнөх оны мөн үеийнхээс 9.1 мянга буюу 14.5 хувиар, үүний дотор үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо 2.1 мянга буюу 5.6 хувиар нэмэгдсэн байна /Хүснэгт 1/.

Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын хувьд 1-9 ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага 2.9 мянга буюу 9.3 хувиар нэмэгдсэн бол 10-19 ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага 521 буюу 16.2 хувиар, 20-49 ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага 166 буюу 7.1 хувиар, 50-иас дээш ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага 79 буюу 6.3 хувиар тус тус буурчээ.

Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоог өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээнийх 1.2 мянга буюу 28.3 хувь, үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагааных 363 буюу 12.8 хувь, зочид буудал, зоогийн газрынх 153 буюу 10.8 хувиар тус тус буурсан бол бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварынх 3.6 мянга буюу 22.9 хувь, барилгынх 83 буюу 6.2 хувь, боловсролынх 92 буюу 4.5 хувь, боловсруулах аж үйлдвэрийнх 85 буюу 3.6 хувиар тус тус өссөн байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоог өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад Завхан аймгийнх 66 буюу 10.5 хувь, Дорноговь аймгийнх 52 буюу 10.7 хувь, Дархан-Уул аймгийнх 120 буюу 10.9 хувь, Төв аймгийнх 139 буюу 18.9 хувиар буурсан бол Ховд аймгийнх 159 буюу 19.5 хувь, Баянхонгор аймгийнх 81 буюу 16.4 хувь, Өвөрхангай аймгийнх 79 буюу 13.7 хувь, Булган аймгийнх 56 буюу 13.7 хувь, Улаанбаатар хотынх 2.3 мянга буюу 9.7 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 1

Аж ахуйн нэгж, байгууллагын тоо, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

	2008 I-VI	2009 I-VI	2010 I-VI	$\frac{2009 \text{ I-VI}}{2008 \text{ I-VI}}$ %	$\frac{2010 \text{ I-VI}}{2008 \text{ I-VI}}$ %	$\frac{2010 \text{ I-VI}}{2009 \text{ I-VI}}$ %
Бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоо	60 354	62 509	71 579	103.6	118.6	114.5
Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо	35 616	37 661	39 764	105.7	111.6	105.6
Үүнээс: Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа	22 525	24 135	26 478	107.1	117.5	109.7